



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 26 өдөр

Дугаар А/90

Есөнбулаг

┌ Үнэлгээний хороо байгуулах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалт, 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсэг, 50.1.2 дахь заалт, Сангийн сайдын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн “Үнэлгээний хорооны үйл ажиллагаа, урамшууллын журам” А/254 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Говь-Алтай аймгийн Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэгт бараа материал нийлүүлэх ажлын гүйцэтгэгч сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үнэлгээний хорооны дарга:	Х.Баатарзориг	(Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга)
Гишүүдэд:	Б.Золзаяа	(Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн)
	Ё.Нарангарав	(Хөндлөнгийн төлөөлөл) (тохиролцсоноор)
	Ц.Батсайхан	(Есөнбулаг сумын иргэн)
Нарийн бичиг:	Ч.Мэндбаяр	(Худалдан авах ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн)

2.Тендерийн баримт бичгийг боловсруулан гаргаж, худалдан авах ажиллагааг хугацаа алдалгүй чанартай зохион байгуулж, дүнг хуулийн хугацаанд танилцуулахыг Үнэлгээний хороо (Х.Баатарзориг)-нд үүрэг болгосугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ